

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН СЭДЭВ “АЙМГИЙН ТЕЗ-ИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ТӨСВИЙН
ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ, ЗАРЛАГЫГ БУУРУУЛАХ, ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН
ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР ДҮГНЭЛТ ГАРГАХ”**

АУДИТЫН КОД: БУА-2025/07-4-ШТА

**БУЛГАН АЙМАГ
2025 ОН**

Булган дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Д.Батцогт
Утас: 7034-2580 Цахим хаяг: Battsoqtd@audit.gov.mn
Аудитын менежер : Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Содном
Утас: 7034-2495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn
Аудитор: А.Сувдаа
Утас: 7034-2716 Цахим хаяг: Suvdaaa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. bulgan@audit.gov.mn

Агуулга

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгтийн товъёг.....	3
Хавсралтын товъёг	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4
НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	6
ХОЁР. ТӨСВИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХАД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ	7
ГУРАВ. ТӨСВИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР	8
ДӨРӨВ. ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР	9
4.1 Урсгал зардал.....	9
ТАВ. ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР	10
5.1 Орон нутгийн хөгжлийн сан	11
5.2 Авто замын сан	11
5.3 Байгаль хамгаалах сан.....	12
ДҮГНЭЛТ: 13	
ЗӨВЛӨМЖ:	13

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БОГ	Байгаль орчны аялал газар
БОНХОБТХ	Бүс орон нутаг, хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс
БУА	Булган аймаг
БХС	Байгал хамгаалах сан
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЗЗНДНТУТХ	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын их хураг

Хүснэгтийн товъёг

Хүснэгт 1: УИХ-аас баталсан орлогыг нэмэгдүүлсэн дүн	8
Хүснэгт 2: Батлагдсан орон тоог байгууллагаар харуулбал	9

Хавсралтын товъёг

Хавсралт 1: ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх иргэдийн саналгүй, үр өгөөжийн тооцоолол хийгдээгүй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний дэлгэрэнгүй жагсаалт	14
Хавсралт 2: Байгал хамгаалах, нөхөн сэргээх төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд холбогдох хууль, эрх зүйн шийдвэртэй нийцээгүй төслийн жагсаалт	16
Хавсралт 3: Байгаль хамгаалах, нөхөн сэргээх төсөл, арга хэмжээнд тооцоолол болон техникийн тодорхойлолтгүй төсөл арга хэмжээний төсвийг бууруулах жагсаалт	20

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 болон Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын Хорооны 2024 оны Аудитын сэдэв батлах 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аудитыг гүйцэтгэлээ.
Аудитын зорилт	Булган аймгийн Засаг даргын 2026 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргах” сэдвээр нийцлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, дүнг аймгийн ИТХ-д хүргүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - Төсвийн төсөл нь улс, аймгийн тогтвортой хөгжлийн бодлого, төсвийн тухай хууль тогтоомжид нийцэж заасан шалгуурыг хангасан эсэх. - Аймгийн орлого, зарлагын төлөвлөлтийг хууль журмын дагуу арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр төсөвлөсөн эсэх. - Аймгийн жилийн төсвийн бүрдүүлэлт зарцуулалтад дүн шинжилгээ хийж, холбогдох баримт бичгийн бүрдүүлэлт хангагдсан эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн 2025 оны батлагдсан төсөв, төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл, 2026 оны төсвийн төсөл, төсвийн шууд захирагчид болон төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтүүд, аймгийн ИТХ, СТСХ, БОНХОБТХ, ГХБХБГ, БОГ, Татварын газрын 2026 оны төсвийн төсөлд оруулсан орлого, зарлагын санал, тооцооллуудыг хамруулан гүйцэтгэлээ.
Аудитын стандарт, арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2022 оны А/67 дугаар

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал” болон бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

Аудитад төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, заавар аргачлал, түүний дотор Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хуулийн 5 дугаар бүлэг, Өрийн удирдлагын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын хуулийн 6.9-д заасан шаардлагыг гол шалгуур болголоо.

Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Батцогт хянан удирдаж, аудитын менежер Ж.Энхцоодол аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор П.Содном, А.Сувдаа нар хийж гүйцэтгэлээ.

Аудитыг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аймгийн төсвийн төслийг хүлээн авч 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр хүртэл гүйцэтгэж, үе шатны хяналтаар хянуулж, аудитын тайлан, нотлох баримтыг бэлтгэн ажиллалаа.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-т заасан Булган аймгийн Засаг даргаас ирүүлсэн ТЕЗ-ийн 2026 оны орон нутгийн төсвийн төсөлд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т заасны дагуу дүгнэлт гаргалаа.

Аймгийн төсвийн орлого 2025 оны 10 дугаар сарын байдлаар 66.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь өмнөх оны мөн үеэс 5.9 сая төгрөгөөр буурсан, орон нутгийн төсвийн зарлага 74.5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй нь өмнөх оны мөн үеэс 4.5 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй үзүүлэлттэй байна. /Аймгийн нийгэм эдийн засгийн байдал статистик эмхэтгэл -2025.10 сар/

Аймгийн Засаг даргын 2026 оны төсвийн төслийг улс, аймгийн тогтвортой хөгжлийн бодлого, зорилт болон Булган аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөө, Булган аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр нийцүүлэн төлөвлөсөн байна.

Булган аймгийн 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, батлагдаагүйгээс түүнд чиглэсэн эсэхийг дүгнэх боломжгүй байна.

УИХ-ын 2024 оны “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолын 01 дүгээр хавсралтын 2.1-д Хойд бүсэд Булган, Орхон, Хөвсгөл аймаг, 3.3-д “Бүсийн хөгжлийн зорилго нь Оросын Холбооны Улс болон Европын орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, Хөвсгөл нуур, Сэлэнгэ мөрний сав газрын эко систем, байгаль, түүх, соёлын өвд тулгуурлан Байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн бүс бөгөөд аж үйлдвэрийн дэд бүс болно” хэмээн тодорхойлсон.

Дээрх тогтоолд дараах зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

3.3.7.Булган аймгийн Эгийн голд эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулгын үндсэн эх үүсвэр 310 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц барина.

3.3.9.Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж, Хөвсгөл, Булган аймагт салбар дундын дадлага, үйлдвэрлэлийн бааз байгуулна.

3.3.10.Сэлэнгэ мөрний сав газрын усны урсац бүрэлдэх эх, нэн ховор, ховор амьтан ургамал бүхий 3.1 сая га газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авна.

3.3.11.Орон нутгийн хөгжлийн төвүүдэд үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр, логикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг тэргүүн ээлжид дэмжинэ.

3.3.20.Бага-Илэнх боомт-Хутаг-Өндөр сум чиглэлийн авто замыг барина.

ХОЁР. ТӨСВИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХАД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

Булган аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны төсвийн төслийн боловсруулахдаа Сангийн яамнаас ирүүлсэн "Орон нутгийн 2026 оны төсвийн төсөл боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл"-ийг удирдлага болгосон байна. Үүнд:

1. Орон нутгийн 2026 оны төсвийн орлогын чиглэлээр

➤ Ирэх оны орон нутгийн төсвийн орлогыг бодит тоон мэдээлэлд суурилах, үндэслэлгүйгээр нэмэгдүүлэхгүй байх.

➤ Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.1-д Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 60 хувийг улсын төсвийн орлого байхаар, мөн зүйлийн 23.6.10-т уг татварын 40 хувийг орон нутгийн төсвийн орлого байхаар тус тус заасан тул 2026 онд орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг хянасан дүнгээс нэмэгдүүлэхгүй байх.

2. Орон нутгийн 2026 оны төсвийн зарлагын чиглэлээр

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд заасан төрийн албаны бүтцийг тэлэхгүй байх, төрийн албыг цомхон, давхардалгүй, чадварлаг бүтцээр ажиллуулах зорилтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын орон тоог 9 хувь бууруулах бодлогын арга хэмжээг 2025 оны төсвийн тодотголд тусгаж улсын хэмжээнд хэрэгжүүлсэн. Мөн тус арга хэмжээг 2026 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тооцож Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг боловсруулан батлуулсан. Иймд Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах байгууллагуудын чиг үүрэгт дүн шинжилгээ хийн бүтэц, зохион байгуулалтын оновчтой хувилбарыг сонгож, нэгтгэн зохион байгуулах замаар Улсын Их Хурлын баталсан Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд аймгийн суурь зарлагад туссан төсөв, цалингийн сан орон тооны хязгаарт багтаан үйл ажиллагаа явуулах.

➤ Төрийн албан хаагчийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлыг 2026 онд тэтгэвэрт гарах хүсэлтээ өгсөн төрийн албан хаагчийн тоонд үндэслэн төлөвлөж, тухайн байгууллагын төсөвт тусгах бөгөөд, хуулийн дагуу өндөр насны тэтгэвэрт гарч байгаа төрийн албан хаагчид тэтгэмжийг бүрэн олгоно, хэсэгчилсэн байдлаар олгохгүй.

Шаардлагатай бол бүх шатны төсвийн захирагч нар Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт заасны дагуу төсөвтөө зохицуулалт хийх замаар төрийн албан хаагчид олгох тэтгэмжийн зардлыг бүрэн олгох зарчмыг баримтална.

➤ Төрийн албан хаагч тэтгэвэр тогтоолгох эрх нь үүссэн ч өөрөө хүсвэл Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэгт заасны дагуу үргэлжлүүлэн ажиллах хүсэлтээ өгсөн бол тухайн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээ, туршлага, эрүүл мэндийн байдал зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр үргэлжлүүлэн ажиллуулах зарчмыг

баримталж шийдвэрлэн, энэ талаарх чиглэлийг төсвийн шууд захирагч нарт хүргүүлэх.

➤ Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.4, 3.5, 3.6 дах зүйлд заасан зориулалт, арга хэмжээний зардлын тооцооллыг Сангийн яам хянаж, Засгийн газраас өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал баталсан түвшнээс бууруулахгүйгээр орон нутгийн төсөвт тусгаж, батлуулах зэрэг чиглэлийг өгсөн байна.

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ

Булган аймгийн Засаг даргын 2026 оны төсвийн төсөлд санхүүгийн дэмжлэг 2,714.0 сая, орон нутгийн орлого 65,122.1 сая, ОНХНС-аас 10,666.9 сая, оны эхний үлдэгдлээс 7,111.5 сая нийт эх үүсвэр 85,614.7 сая, нийт зардлыг 85,614.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тооцсон байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2026 оны төсвийн төсөлд аудит хийж дараах санал, дүгнэлтийг аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүлж байна.

ГУРАВ. ТӨСВИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Аймгийн 2026 оны төсвийн орлогыг 59,707.3 сая төгрөгөөр Сангийн яаманд хянуулж, УИХ 61,310.6 сая төгрөгөөр баталсныг 3,811.5 сая төгрөгөөр орлогыг нэмэгдүүлж, нийт төсвийн орлогыг 65,122.1 сая төгрөг байхаар төсвийн төсөлд тусгасан байна.

Хүснэгт 1: УИХ-аас баталсан орлогыг нэмэгдүүлсэн дүн

№	Орлогын нэр төрөл	УИХ-ын баталсан дүн	Аймгийн төсөлд тусгасан дүн	/сая төгрөг/ Нэмэгдүүлсэн орлого	
				Дүн	Хувь
1	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	19,500.0	20,000.0	500.0	2.6
2	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	4,100.0	5,009.4	909.4	22.2
3	Газрын төлбөр	833.2	1,713.3	880.1	105.6
4	Ойн нөөц ашигласны төлбөр	488.0	519.1	31.1	6.4
5	Ан агнуурын нөөц ашигласны төлбөр	19.23	19.28	0.05	0.26
6	Төсөвт байгууллагын өөрийн орлого	14.0	1,302.7	1,288.7	--
7	Торгуулийн орлого	2,740.0	2,908.0	168.0	6.1
8	Түрээсийн орлого	46.0	60.2	14.2	30.8
9	ТБОНӨ бүртгэлтэй хөрөнгө борлуулсан орлого	90.0	110.0	20.0	22.2
Нийт дүн		27,680.5	30,175.5	3,811.5	

Торгуулийн орлогын сүүлийн 2 жилийн ногдуулалт, төлөлтөд судалгаа хийж үзэхэд 2024 оны ногдуулсан торгуулийн дутуу 121.0 сая, 2025 оны ногдуулсан торгуулиас 346.0 сая төгрөгийн өр байгаа бөгөөд тус орлогыг дээрх онуудын дутуу

төлөгдсөн орлогын 30 хувь 150.0 сая төгрөгийг 2026 онд нэмэх боломжтой гэж үзэж байна. Энэ нь төрийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллагуудын уялдаа, хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжих боломжтой юм.

Аймгийн төсвийн татварын орлогоос цалин хөлсний орлогыг УИХ-аас 19,500.0 сая төгрөгөөр баталж ирүүлсэн боловч зардлыг санхүүжүүлэх зорилгоор үндэслэлгүйгээр 500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 20,000.0 сая төгрөгөөр тооцсон нь төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх зарчмыг алдагдуулсан нь төсвийн орлогын тухайн нэр төрлийн орлого тасрах нөхцөл үүсэж болзошгүй байна.

ДӨРӨВ. ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

4.1 Урсгал зардал

Аймгийн төсвийн зарлагыг УИХ-аас 64,024.6 сая төгрөгөөр баталсан дүнгээс 5,793.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж аймгийн төсвийн нийт зарлагыг 69,817.7 сая төгрөгөөр төсвийн төсөлд тусгасан байна.

Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчдад олгох тэтгэмжээс 126.9 сая төгрөг хасах.

Тус тэтгэмжээс 9 сумын орлогч дарга нарын 101.6 сая, улиран сонгогдсон 2 сумын багийн дарга, багийн засаг дарга хийж байх хугацаанд сумын ИТХ-ын дарга болсон албан хаагчид байна.

Энэ нь ЗЗНДНТУТХ-ийн 60 дугаар зүйл аймгийн Засаг даргын бүрэн эрх 60.1.20 “аймгийн Засаг даргын орлогч, тамгын газрын даргыг томилох, чөлөөлөх, огцруулах;” 78.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно.” гэж заасан байдаг.

Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлд Засаг даргын орлогч нь төрийн улс төрийн албан хаагч гэж заасан байх боловч МУЗЗНДНТУТ хуулийн 78 дугаар зүйлд тухайн албан тушаалтныг сонгуулийн үр дүнгээр албан тушаалаас чөлөөлөхөд тэтгэмж олгох талаар зохицуулаагүй байна. Энэ нь аймгийн Засаг даргад ЗЗНДНТУТ хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.20 дахь хэсгээр олгосон бүрэн эрхээр зохицуулсан харилцаа байх бөгөөд тус албан тушаал нь сонгуулийн үр дүнтэй шууд хамааралтай албан тушаал биш юм.

УИХ-аас цалин, хөлсний зардлыг 20,148.5 сая төгрөгөөр баталсныг аймаг 6,819.3, сум 16,367.3 сая нийт 23,186.6 сая төгрөгөөр болгон 3038.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн төсөлд тусгасан байна.

Хүснэгт 2: Батлагдсан орон тоог байгууллагаар харуулбал

№	Байгууллагын нэр	УИХ баталсан 2026	Аймаг хуваарилсан 2026 он	Өссөн
1	Аймгийн ИТХ	9	15	6
2	Аймгийн ЗДТГ	71	90	19
3	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар	6	9	3

4	Орон нутгийн Өмчийн газар	7	10	3
5	Худалдан авах ажиллагааны газар	6	7.5	2
6	Байгаль орчны газар	36	45	9
7	Сувиллын ясли	9	13	4
8	Сумын ЗДТГ	366	406	40
9	Сумын ИТХ	45	49	4
10	Ойн анги	12	12	-
	Нийт	567	657	90

Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах байгууллагуудын чиг үүрэгт дүн шинжилгээ хийн бүтэц, зохион байгуулалтын оновчтой хувилбарыг сонгож, нэгтгэн зохион байгуулах замаар Улсын Их Хурлын баталсан Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд аймгийн суурь зарлагад туссан төсөв, цалингийн сан орон тооны хязгаарт багтаан үйл ажиллагаа явуулах чиглэлийг хэрэгжүүлээгүй байна.

ТАВ. ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 717.0 сая төгрөгийн 9 хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээг иргэдийн саналгүй, үр өгөөжийн тооцоололгүй тусгасан нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1¹, 7.3², Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталгаажсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3³-т заасантай нийцээгүй байна. Иймд сангийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх. (Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харах)

Өмнөх жилээс шилжин ирсэн гэх 2 төсөл, хөтөлбөр арга хэмжээ нь 2025 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1⁴-д заасны дагуу хэрэгжээгүй 13.1.2⁵-д заасны дагуу төсвийн хэмнэлтэд тооцогдсон тул урьд оноос шилжин ирэх бус шинээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд тусгаагүй нь Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталгаажсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 7.5.7⁶-д заасантай бүрэн нийцээгүй байна. Тухайлбал: “Халуун усны барилга шинээр барих (Баяннуур сум)” 260.0 сая төгрөг,

¹ Аймаг, нийслэлийн түвшинд дараах үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлнэ. Үүнд: 4.1.2 Сум, дүүргийн иргэдээр дэмжигдсэн сум, дүүргийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх боломжгүйгээс аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр хүргүүлсэн жагсаалтад орсон байх

² Ажлын хэсэг аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг сум, дүүргээс ирүүлсэн сум, дүүргийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад үндэслэн дараах үзүүлэлтүүдийг харгалзан үзэж боловсруулна. Үүнд: 7.3.4. Хөрөнгө оруулалтын урьдчилан тооцсон төсөвт өртгийг үр өгөөж хүртээгчдийн тоонд харьцуулсан харьцаа”

³ Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхөд дараахь зүйлсийг баримтална: Үүнд 6.3.5. иргэдийн оролцоог хангасан байх гэж заасантай нийцээгүй

⁴ батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах

⁵ энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох

⁶ “аймаг, нийслэлийн Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад дараахь зүйлсийг тусган д. хэрэгжүүлэх хугацаа”

“Гудамжны гэрэлтүүлэг (Булган сум 1-р баг)”-250.0 сая төгрөг төсөл арга хэмжээг төсвийн төсөлд засаж тусгах.

ОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй төлөвлөсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно:” 60.3.6-д “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.”, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.2-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

5.1 Орон нутгийн хөгжлийн сан

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас шилжих 3,128.3 сая төгрөгийн төсөвт 7 төсөл арга хэмжээг 2,194.9 сая, шинээр хэрэгжих 2,553.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл арга хэмжээг 1,690.9 сая, тоног төхөөрөмж бэлтгэхээр 402.2 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээ нийт 6,083.5 сая төгрөгийн төсөв өртөгтэй 22 төсөл арга хэмжээнд 4,288.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна.

Шинээр хэрэгжүүлэх “Эрүүл мэндийн төвийн их засвар (Гурванбулаг)” 550.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2026 онд 230.0 сая төгрөгөөр санхүүжилт олгохоор тусгасан тус хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь зураг төсөвгүй нь Төсвийн тухай хуулийн 24.6⁷, 29.4⁸-д заасантай нийцэхгүй тул 2026 онд санхүүжих хөрөнгийн дүнгээр хасах,

5.2 Авто замын сан

Авто замын хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд 2,527.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл арга хэмжээг 1,737.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна.

Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд тусгасан “Бүрэгхангай-Орхон сум чиглэлийн хатуу хучилттай авто замын зураг төсөв боловсруулах” 200.0 сая төгрөг, “Сумдад авто замын зураг төсвийг шинэчлэх, шинээр боловсруулах (Баяннуур, Булган сум 5,6-р баг)” 60.0 сая төгрөгийн төсөл, хөтөлбөр арга хэмжээ нь Авто замын тухай хуулийн 24.3⁹, 24.4¹⁰,

⁷ Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ

⁸ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана,

⁹ Улсын авто замын сангийн хөрөнгөөр олон улс, улсын чанартай авто замын, нийслэл, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр нийслэл, орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг тус тус санхүүжүүлнэ.

¹⁰ Авто замын сангийн хөрөнгөөр авто замын арчлалт, урсгал засвар, гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засварын ажлыг тэргүүн ээлжинд санхүүжүүлнэ.

24.5¹¹-т заасантай нийцээгүй тул 24.8¹²-д заасны дагуу тус сангийн хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнээс хасах,

5.3 Байгаль хамгаалах сан

Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 2026 онд шилжих хөрөнгө оруулалтаар 3,780.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл арга хэмжээнд 1,869.5 сая, шинээр хэрэгжих 7715.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 41 төсөл арга хэмжээг 5922.3 сая төгрөг нийт 49 арга хэмжээг 7791.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгажээ.

Төсвийн төсөлд байгаль хамгаалах, нөхөн сэргээх төсөл, хөтөлбөр, арга хэмжээнээс зураг, төсөвгүй, ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь тодорхой бус, эцсийн өмчлөгч нь тодорхойгүй, үйл ажиллагааны чиглэл ойлгомжгүй, техникийн тодорхойлолтгүй, үйл ажиллагааны зардлаар тусгах боломжтой зэрэг нийт 950.0 сая төгрөгийн 10 төсөл арга хэмжээг тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24.6¹³, 29.4¹⁴, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3¹⁵, Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоол “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.5-д тусгагдаагүй арга хэмжээ, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоол “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.1.4¹⁶, 3.2.3.3¹⁷-д заасантай нийцээгүй тул санхүүжих дүнгээр хасах (*Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос харах*),

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд туссан 266.9 сая төгрөгөөр санхүүжих 5 төсөл, арга хэмжээнд тооцооллыг давтан хийхэд ирүүлсэн саналаас илүү, техникийн тодорхойлолтгүй тоног төхөөрөмж зэргийг тусгасан тул 59.8 сая төгрөгөөр бууруулах (*Дэлгэрэнгүйг хавсралт 3-аас харах*),

Өмнөх жилээс шилжин ирсэн ажлаар тусгасан “Цэвэр усны нөөцийг хамгаалах зорилгоор шугам хоолойг хлоржуулах төхөөрөмжийн засвар хийж тоноглол солих” 140.0 сая төгрөг, “Хөрсний доройтлыг бууруулж, усыг зохистой ашиглах зорилгоор

¹¹ Авто замын сангаас авто замын засвар, арчлалтын ажлыг хариуцсан байгууллагын үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх, судалгаа шинжилгээний ажил хийх, техник технологийг шинэчлэх, хөндлөнгийн хяналт тавих, хөдөлгөөнт эргүүл ажиллуулах, мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх, авто замын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг санхүүжүүлнэ.

¹² Авто замын сангийн хөрөнгийг энэ хуулийн 24.3, 24.4, 24.5-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно

¹³ Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ,

¹⁴ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана

¹⁵ Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно: 13.3.2.хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ

¹⁶ Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 3.1.2, 3.1.3-т заасан төсөл, арга хэмжээний саналыг ирүүлэхдээ дараах шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг судалж, холбогдох тайлан болон баримт бичгийг хавсаргасан байна: 3.1.4.1.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан болон уялдсан байдал, 3.1.4.2.хэрэгцээ шаардлага, үндэслэл; 3.1.4.4.төслийн зардлыг бүрэн зөв тооцсон эсэх;

¹⁷ холбогдох баримт бичиг, нотлох баримтаар баталгаажсан, төлөвлөлт, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх

дулаан цэвэр хэрэглээний халуун усны шугам шинээр татах 500м (Булган сум 9,10,11-р орон сууц)” 680.1 сая төгрөгийн төсөл, хөтөлбөр арга хэмжээ нь 2025 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д заасны дагуу хэрэгжээгүй 13.1.2-д заасны дагуу төсвийн хэмнэлтэд тооцогдсон тул шилжин ирэх бус шинээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд тусгаагүй нь Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталгаажсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 7.5.7-д заасантай бүрэн нийцээгүй тул төсвийн төсөлд шинээр хэрэгжих төсөл арга хэмжээний жагсаалтад оруулах.

ДҮГНЭЛТ:

- Зардлыг санхүүжүүлэх зорилгоор үндэслэлгүйгээр цалин хөлсний орлогыг нэмэгдүүлсэн нь төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх зарчмыг алдагдуулсан байна.
- Орон нутгийн төсвийн зардлыг төлөвлөхдөө арга хэмжээний хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхойлохгүй, төсвийн задаргаа байхгүй, тооцоо судалгаа хийгээгүй зэрэг нийтлэг алдаа дутагдал байгаа нь зардлыг бодитой бус төлөвлөх эрсдэлийг бий болгож байна.
- Орон нутгийн 9 байгууллагын УИХ-аас батлагдсан орон тооны хязгаарыг 15.8 хувиар буюу 90 хүнээр нэмэгдүүлэн тооцсоноос цалин, НДШ-ийн зардалд 3,513.3 сая төгрөгийг нэмж төлөвлөсөн байна.
- Зураг төсөв, тооцоо судалгаагүй хөрөнгө оруулалтыг төлөвлөсөн нь хууль тогтоомж зөрчих, төлөвлөсөн ажил хугацаандаа хэрэгжихгүй байх, улмаар өөр хэрэгцээ шаардлагатай, ач холбогдолтой хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх боломжийг хааж төсвийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулах эрсдэл байна.
- Хог хаягдлын хураамжийн орлогын хэмжээг хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх зардлын тарифыг тооцож, түүнд үндэслэн хог хаягдлын хураамжийн хэмжээг тогтоон орлого нэмэгдүүлэх боломж байна.

ЗӨВЛӨМЖ:

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА Ж.ГАНБОЛД ТАНАА:

- Орон нутгийн төсвөөс төлөх дамжуулангийн зээлийн 2026 оны төлөх хуваарьт 1,092.7 сая төгрөгийн зээлийн төлбөрийн эх үүсвэрийг аймгийн 2026 оны төсөвт бодитоор төлөвлөх;
- Хог хаягдлын хураамжийн хэмжээг тогтоохдоо Сангийн сайд болон БОАЖС-ын 2018 оны 192, А/243 дугаартай “Аргачлал батлах тухай” аргачлалыг үндэслэн энгийн хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх зардлын тарифыг тооцож, түүнд үндэслэн хог хаягдлын хураамжийн хэмжээг тогтоон орлого орлого нэмэгдүүлэх боломжийн талаар сумдын ИТХ-дад нэгдсэн бодлого, чиглэл хүргүүлэх;

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР ТАНАА:

- УИХ-аар баталсан орон тооны хязгаарыг баримтлан, чиг үүргийн давхардлыг арилгах чиглэлээр ажлын байрны болон чиг үүргийн шинжилгээг хийж, төсвийн

зарлагыг бууруулах чиглэлд санаачилга, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

- Төсвийн суурь зарлагад тооцогддоггүй боловч аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулдаг урсгал зардлуудад дүн шинжилгээ хийж зардал бууруулах, төсвийн үр ашгийг дээшлүүлэх чиглэлд бодлогын арга хэмжээ авч ажиллах;
- Төсвийн төсөлд тусгагдах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг холбогдох Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолыг баримтлан анхан болон дунд шатны боловсруулалт, хяналтыг сайжруулах, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын 3.1.4, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр журмын 6.3, Сангийн сайдын 2021 оны 86 дугаарын журмын 4.1, 7.3-д заасныг бүрэн хэрэгжүүлэх;

-oOo-

Хавсралт 1: ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх иргэдийн саналгүй, үр өгөөжийн тооцоолол хийгдээгүй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний дэлгэрэнгүй жагсаалт

/мянган төгрөг/

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалт /2026/					
2. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ				315,000.00	315,000.00
2.2	Цэцэрлэгийн барилгын их засвар (Булган сум 2-р цэцэрлэг)	2026	2026	300,000.00	300,000.00
2.8	Сорилтын лабораторийн барилгын засварын ажил (Стандарт хэмжил зүйн хэлтэс)	2026	2026	15,000.00	15,000.00
3. Бараа, тоног төхөөрөмж				402,200.00	402,200.00
3.1	УДД-4 төвд насос, дагалдах хэрэгсэл	2026	2026	36,000.00	36,000.00
3.2	Даралтны эталон, дулаан хэмжигч тоног төхөөрөмж (Стандарт хэмжил зүйн хэлтэс)	2026	2026	46,200.00	46,200.00
3.3	Мал эмнэлгийн газрын тоног төхөөрөмж	2026	2026	100,000.00	100,000.00
3.4	Шүдний бор машин 2ш (Баяннуур, Бүгат)	2026	2026	30,000.00	30,000.00
3.5	"Gene expert" аппарат (Сүрьеэ, Дох-н шинжилгээнд шаардлагатай аппарат)	2026	2026	85,000.00	85,000.00
3.6	ХЖТ-д тоног төхөөрөмж /Лед дэлгэц/	2025	2026	85,000.00	85,000.00
3.7	БТСГ-н харьяа усан спорт сургалтын төвийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл	2026	2026	20,000.00	20,000.00
Нийт дүн				717,200.00	717,200.00

Аймгийн ТЕЗ-ийн 2026 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргах

Хавсралт 2: Байгал хамгаалах, нөхөн сэргээх төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд холбогдох хууль, эрх зүйн шийдвэртэй нийцээгүй төслийн жагсаалт

/мянган төгрөг/

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт /2026/						Тайлбар
№	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг (мян.төг)	2026 онд санхүүжих дүн (мян.төг)	
Шилжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ				75,000.00	75,000.00	
7	Нарсны боргоцой цайруулах хатаах тоног төхөөрөмж (Хангал сум Хялганат тосгон)	2025	2026	75,000.00	75,000.00	2025 оны баталсан ТХАХ-д тусгагдаагүй /2025 онд ойн ангиудын тоног төхөөрөмж, арчилгаа, хамгаалалтын ажлын зардал гэсэн нэрээр ТХАХ батлагдаж тодотголоор хасагдсан/, Техник эдийн засгийн судалгаагүй, албан ёсны хүсэлт ирүүлээгүй нь ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоол “ Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын • 3.1.4.Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 3.1.2, 3.1.3-т заасан төсөл, арга хэмжээний саналыг ирүүлэхдээ дараах шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг судалж, холбогдох тайлан болон баримт бичгийг хавсаргасан байна: 3.1.4.5.холбогдох баримт материал, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, гэж заасантай нийцэхгүй Шилжин ирэх ажил бус- шинээр хэрэгжүүлэх ажлаар тусгах Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталгаажсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 7.5.7-д “аймаг, нийслэлийн Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад дараах зүйлсийг тусган д. хэрэгжүүлэх хугацаа,” гэж заасантай бүрэн нийцээгүй байна.
1. Усны нөөц хамгаалах, усан хангамжийг сайжруулах чиглэлээр				50,000.00	50,000.00	
12	Усан хангамжийн худгийн цэвэршүүлэгч шүүлтүүр (Баяннуур сум)	2026	2026	50,000.00	50,000.00	Хүсэлт, техникийн тодорхойлолт, хүчин чадлын үзүүлэлт байхгүй нь ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоол “ Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын • 3.1.4.Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 3.1.2, 3.1.3-т заасан төсөл, арга хэмжээний саналыг ирүүлэхдээ дараах шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг судалж, холбогдох тайлан болон баримт бичгийг хавсаргасан байна: 3.1.4.5.холбогдох баримт материал, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталгаажсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын • 7.5.7-д “аймаг, нийслэлийн Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад дараах зүйлсийг тусган г. хүчин чадал” гэж заасантай нийцээгүй тул хасах

Аймгийн ТЕЗ-ийн 2026 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргах

2. Ой, цөлжилтийн талаар:				65,000.00	65,000.00	
17	Сумын нутаг дэвсгэрт авто замын ажлын нөлөөгөөр эвдэрсэн 6,6 га газарт нөхөн сэргээлт хийх (Бугат сум)	2026	2026	65,000.00	65,000.00	ЗГ-ын 2022 оны 2 дугаар тогтоол "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.5-д тусгагдаагүй арга хэмжээ тул тус журмын 3.7-д заасны дагуу хасах "Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн заалтаас: • 25.1.2.Байгалийн баялаг ашигласан газар, орчныг засаж сайжруулах, тохижуулах. • 31.4. Байгаль орчинд сөрөг нөлөөлөл бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагааныхаа сөрөг нөлөөллийг бууруулах, зогсоох болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг жил бүр төсөвтөө тусган хэрэгжүүлэх. "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн заалтаас: • 9.4.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах болон нөхөн сэргээлт хийх журам, аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нөхөн сэргээлтийн стандартыг холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллага тус тус батална. • 9.12.Байгаль орчны менежментийн болон уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавина. "Ашигт малтмалын тухай" хуулийн заалтаас... • 38.1.2.энэ хуулийн 38.1.1-д заасан төлөвлөгөөнд хүрээлэн байгаа орчны бохирдолтыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, эвдэгдсэн газрыг булах, тэгшлэх, ургамалжуулах замаар цаашид нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглаж болох нөхөн сэргээх арга хэмжээг тусгах; • 39.1.4.энэ хуулийн 38.1.2-т заасан нөхөн сэргээх арга хэмжээг тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. • 39.3.Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээг бүрэн биелүүлээгүй тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 39.1.9-д заасан хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг мэргэшсэн байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардагдах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулна. • 39.7.Тухайн жилийн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийгээгүй тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга болон мэргэжлийн хяналтын алба хамтран дараагийн жилийн олборлолтын ажлыг эхлүүлэхгүй байх эрхтэй. • 42.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон түүний байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчийг иргэд дундаасаа сонгон ажиллуулж болно. Газрын хэвлийн тухай" хуулийн заалтаас: • 20.2.4.газрын хэвлийг ашиглах явцад эвдэрсэн газрыг аюул осолгүй болгож, цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулан анх зөвшөөрөл олгосон нутгийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх; • 411.2.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үндэслэн байгаль орчинд нөлөөлөх
3. Газар, газрын хэвлийг хамгаалах, хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах				1,270,000.00	550,000.00	
26	Уул уурхайн олборлолт болон авто замын бүтээн байгуулалтын улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх зардал	2026	2026	200,000.00	200,000.00	

Аймгийн ТЕЗ-ийн 2026 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргах

						сөрөг нөлөөллийг арилгах, ашигт малтмалын орд, түүний хэсэг дээр малтсан газрыг дарах буюу цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулах, хөрсийг нь нөхөн сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. “Газрын тухай” хуулийн заалтаас: • 55.2.Газрын хэвлийг ашиглагч нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, газрыг хамгаалах, нөхөн сэргээх төсөлтэй байна. • 55.4.Газрыг хамгаалах, нөхөн сэргээх төсөл, түүнд үндэслэсэн төлөвлөгөөг жил бүр боловсруулж, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажуулна. • 55.5.Газрыг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөнд тусгагдсан ажлын гүйцэтгэлийг жил бүр тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, дүгнүүлнэ. • Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нөхөн сэргээлтийн стандартууд: Байгаль орчны яам, Стандарт, хэмжилзүйн үндэсний төв, ШУТИС-ийн Уул уурхайн сургууль, ХААИС, “Хариуцлагатай уул уурхай” ТББ хамтран боловсруулж, мөрдүүлсэн эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн стандартуудыг дор үзүүлэв:- “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт” MNS 5914:2008, (MNS 17.5.1.13-80-ын оронд);- “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал” MNS 5915:2008, (MNS 17.5.1.18:1983-ын оронд);- “Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт” MNS 5916:2008, (MNS 4917:2000 болон MNS 4920:2000 -ын оронд);- “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага” MNS 5917:2008, (MNS 17.5.1.19-92, MNS 4915:2000 болон MNS 4916:2000 -ын оронд);-“Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага” MNS 5918:2008, (MNS 4918:2000 болон MNS 4919:2000 -ын оронд).
28	Булган суманд байгуулах дахивар нөөц авах цэгийн зураг төсөл боловсруулах	2026	2026	20,000.00	20,000.00	• 3Г-ын 2022 оны 2 дугаар тогтоол "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.5-д тусгагдаагүй арга хэмжээ, • ТХТХ-ийн 13.3.Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно: 13.3.2.хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ; тул хасах
30	Хөрсний доройтлыг бууруулж усыг зохистой ашиглах зорилгоор дулааны шугам татах ажлын эхлэл (Булган сум 2-р баг Мээж 1, 2, 3-р гудамж)	2026	2026	960,000.00	240,000.00	Зураг, төсөвгүй нь Төсвийн тухай хуулийн • 24.6.Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ, • 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана, гэж заасантай нийцээгүй тул хасах

Аймгийн ТЕЗ-ийн 2026 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргах

37	Хөрсний бохирдлыг бууруулах эко 00 хийхэд шаардагдах тоног төхөөрөмж (Сайхан сум)	2026	2026	90,000.00	90,000.00	Үйл ажиллагааны чиглэл тодорхойгүй, үр ашгийн тооцоолол байхгүй, агуулгын хувьд ойлгомжгүй • ТХТХ-ийн 13.3.Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно: 13.3.2.хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ; 13.3.3.техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ. тул хасах
5. Ногоон хөгжлийн бодлого, аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээнүүд				100,000.00	100,000.00	
41	Байгал орчны уур амьсгалын өөрчлөлтгүй холбоотой иргэд олон нийтэд нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	2026	2026	100,000.00	100,000.00	Ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх тооцоолол судалгаа байхгүй нь ЗГ-ын 2022 оны 2 дугаар тогтоол "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.5-д тусгагдаагүй арга хэмжээ ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоол "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.1.4.Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 3.1.2, 3.1.3-т заасан төсөл, арга хэмжээний саналыг ирүүлэхдээ дараах шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг судалж, холбогдох тайлан болон баримт бичгийг хавсаргасан байна: 3.1.4.1.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан болон уялдсан байдал, 3.1.4.2.хэрэгцээ шаардлага, үндэслэл; 3.1.4.4.төслийн зардлыг бүрэн зөв тооцсон эсэх; • 3.2.3.3.холбогдох баримт бичиг, нотлох баримтаар баталгаажсан, төлөвлөлт, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх; гэж заасантай нийцэхгүй тул хасах
6.Байгаль орчин бусад арга хэмжээ				110,000.00	110,000.00	
44	Байгаль орчны эсрэг гэмт хэргийг илрүүлэх таслан зогсоох ажилд шаардлагатай тоног төхөөрөмж	2026	2026	15,000.00	15,000.00	• ЗГ-ын 2022 оны 2 дугаар тогтоол "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.5-д тусгагдаагүй арга хэмжээ тул тус журмын 3.7-д заасны дагуу хасах, • Аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагааны зардалд тусгах
46	Байгаль орчны эсрэг гэмт хэргийг илрүүлэх таслан зогсоох зорилгоор хяналт шалгалт хийх авто машин	2026	2026	95,000.00	95,000.00	• ЗГ-ын 2022 оны 2 дугаар тогтоол "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.5-д тусгагдаагүй арга хэмжээ тул тус журмын 3.7-д заасны дагуу хасах, • Аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагааны зардалд тусгах
Нийт дүн				1,670,000.00	950,000.00	

Аймгийн ТЕЗ-ийн 2026 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргах

Хавсралт 3: Байгаль хамгаалах, нөхөн сэргээх төсөл, арга хэмжээнд тооцоолол болон техникийн тодорхойлолтгүй төсөл арга хэмжээний төсвийг бууруулах жагсаалт

/мянган төгрөг/

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт /2026/					Бууруулах дүн	Тайлбар		
№	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг (мян.төг)			2026 онд санхүүжих дүн (мян.төг)	
1. Усны нөөц хамгаалах, усан хангамжийг сайжруулах чиглэлээр					26,858.00	26,858.00	17,000.00	
10	Усны тоо бүртгэлийн ажил зохион байгуулах	2025	2026	26,858.00	26,858.00	17,000.00	Усны хурд хэмжигч-10.0 сая, цооногийн гүн хэмжигч 7.0 сая/ техникийн тодорхойлолт байхгүй нь ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоол “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.1.4.Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 3.1.2, 3.1.3-т заасан төсөл, арга хэмжээний саналыг ирүүлэхдээ дараах шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг судалж, холбогдох тайлан болон баримт бичгийг хавсаргасан байна: 3.1.4.5.холбогдох баримт материал, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, 3.2.3.3.холбогдох баримт бичиг, нотлох баримтаар баталгаажсан, төлөвлөлт, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх гэж заасантай нийцээгүй тул 17.0 сая төгрөгөөр бууруулах	
2. Ой, цөлжилтийн талаар:					65,261.00	65,261.00	16,001.00	
15	Сум дундын ойн ангиуд үр түүх байнгын болон түр талбайг арчлах (30 га)	2026	2026	32,361.00	32,361.00	3,261.00	БОАЖС, СС-ын 2021 оны А/172, 116 хамтарсан тушаалын хавсралтаар дүнгээр тооцоход 3,261.0 мянган төгрөг илүү тусгасныг бууруулах, 2024, 2025 онд хийсэн газар давхардаагүй, үр өгөх жил 5 жил байсан нь 7-8 жил болж өөрчлөгдсөн, СДОА-ууд паспортжуулдаг 2018 онд Орхон суманд түр талбай, Хутаг-Өндөр, Хялганатад сүүлийн 2022 оноос талбайтай болсон ойролцоогоор 20-30га талбай байгаа Талбайг сонгоно, дугаарлана, цэвэрлэгээ, арчилгаа хийнэ, бордоно, шаардлагатай бол түймрийн зурвас байгуулна.	
20	Ойн ангид ротор сийрүүлэгч, хөрс бутлагч үрлэгч модны нүх ухагч (Хангал, Хялганат	2026	2026	32,900.00	32,900.00	12,740.00	Нэг байгууллагаас ирүүлсэн үнийн судалгаагаар 6,100.0+3,980.0=10,080.0 мянган төгрөг НӨАТ орсон, тээврийн зардал ороогүй, тээврийн зардлын тооцоо байхгүй. Ойн 2 ангид нийт 20,160.0 мянган төгрөг тул 12,740.0 мянган төгрөгөөр бууруулах	

Аймгийн ТЕЗ-ийн 2026 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргах

	тосгон, Хутаг-Өндөр сум)						
3. Газар, газрын хэвлийг хамгаалах, хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах				156,800.00	156,800.00	24,700.00	
36	Хөрсний доройтлыг бууруулж, усыг зохистой ашиглах зорилгоор цэвэр ус дулааны шугам шинээр татах (Гурванбулаг, Сэлэнгэ сум)	2026	2026	156,800.00	156,800.00	24,700.00	Гурванбулаг сумын цэвэр ус, дулааны шугам шинээр татах зураг, төсөвгүй Төсвийн тухай хуулийн • 24.6.Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ, • 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана гэж заасантай нийцэхгүй тул 24.7 сая төгрөгөөр бууруулах.
6.Байгаль орчин бусад арга хэмжээ				18,000.00	18,000.00	2,100.00	
43	Цаг-Уурт зориудаар нөлөөлөх зардал	2026	2026	18,000.00	18,000.00	2,100.00	УЦУОШ-ний төвийн 2025.10.08-ны 01/160 тоот хүсэлт, 15.9 сая төгрөгийн тооцоо ирүүлсэн /гүйцэтгэлээр санхүүжилт авдаг-мэргэжилтний тайлбар/ тул 2.1 сая төгрөгөөр бууруулах
Нийт дүн				266,919.00	266,919.00	59,801.00	

-oOo-